



Аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит II хуралдааны  
10 дугаар тогтоолын хавсралт

### БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2017-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төрийн бодлогыг аймгийнхаа онцлогт тохируулан боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх өндөр чадавхтай, зөв зохион байгуулалттай, хариуцлагатай удирдлагын тогтолцоог бүрдүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчинг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэхэд хөтөлбөрийн ЭРХЭМ ЗОРИЛГО оршино.

Энэхүү хөтөлбөрийг боловсруулахад Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2010-2021 оны хөгжлийн хөтөлбөрийг удирдлага болголоо.

#### НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

##### 1.1. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

**Орон нутгийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүнийг жил бүр нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангана.**

1.1.1. Аж ахуйн нэгжүүдийг өрийн дарамтаас гаргахад дэмжлэг үзүүлэн, иргэдийн тогтвортой амьжиргааг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлнэ.

1.1.2. Гэрээгээр гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсөө авч чадахгүй байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг барагдуулахад хяналт тавина.

1.1.3. “Үнэ тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад хяналт тавьж, үр ашгийн хүртээмжийг дээшлүүлнэ.

1.1.4. Эдийн засгийн хүндрэлээс улбаалан ажил, орлого нь хумигдан, зээлээ төлж чадахгүйд хүрч, “Найдваргүй зээлдэгчдийн жагсаалт”-д бүртгэгдсэн аж ахуйн нэгж зээлээ эргэн төлж, зээлийн түүхээ сайжруулах боломжийг судалж, Монгол банк болон арилжааны банкуудтай хамтран ажиллана.

1.1.5. 3-аас доошгүй жил тасралтгүй үйлдвэрлэл эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаагаа өргөтгөхөд нь дэмжлэг үзүүлнэ.

1.1.6. Бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх бичиг баримтын тоог цөөрүүлэх, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалтыг багасгах, хүнд суртлыг арилгах талаар холбогдох газарт уламжилж дэмжлэг үзүүлж ажиллана.



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

1.1.7.Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжиж, “Аймгийн бренд бүтээгдэхүүн” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

1.1.8.Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, аймаг орон нутгийн онцлогт нийцсэн бизнесийн орчинг хөгжүүлнэ.

1.1.9.Үйлдвэрлэл технологийн паркаар дамжуулан дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ.

1.1.10. Барилгын материал үйлдвэрлэл, бага оврын боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.1.11.Жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

1.1.12.Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгах бодлого баримтална.

1.1.13.Малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, боловсруулах болон нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

1.1.14. Цагааннуурын чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.

1.1.15.Гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгож чирэгдлийг багасгана.

### 1.2. ХӨДӨӨ АЖ АХУЙ

*Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон, байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, малын эрүүл мэндийг хамгаалах ажлыг сайжруулах, үүлдэр угсаа, ашиг шимийг дээшлүүлэх, тариалангийн талбайг нөхөн сэргээх, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, өрхийн тариаланг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.*

1.2.1.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх, түүнчлэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

1.2.2.“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Малжуулах” хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.2.3.Төв суурин газар, түүний ойролцоо нутгуудад жижиг фермерийн аж ахуйг хөгжүүлж, нэг малаас авах ашиг шимийн хэмжээг дээшлүүлж, иргэдийн мах сүүний хэрэгцээг хангахын тулд малын үүлдэр угсааг сайжруулна.



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

1.2.4. Мал аж ахуйн мэргэжилтний залуу халааг бэлтгэх, давтан сургах, малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах талаар орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулан ажиллана.

1.2.5. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт, даатгал, татварын уян хатан бодлогоор дэмжих, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчдад ирж байгаа хүндрэлийг багасгахад чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлж, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангана.

1.2.6. Эхний ээлжид хээлтүүлэгч болон цөм сүргийн малыг, улмаар бүх малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.7. Малын тоог чанарт шилжүүлж, генетикийн нөөцийг хамгаалах, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, замаар нутгийн үүлдэр омгийн малын чанарыг сайжруулан, ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг дэс дараатай зохион байгуулж, мал үржлийн нэгжүүдийг зээл, санхүүгийн бодлогоор дэмжинэ.

1.2.8. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд санаачлага гаргасан аж ахуйн нэгж, иргэдийг зээлийн бодлогоор дэмжиж, сум бүрт тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажил зохион байгуулна.

1.2.9. Хөдөөгийн хүн ам болон мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрт худаг гаргаж, хуучин худгийг сэргээн сайжруулна.

1.2.10. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, төлөв байдлыг тогтоох, хянах, сэргээн сайжруулах, доройтол, талхлагдал, аймаг, сум дундын отрын бүс байгуулах, цөлжилтийг бууруулах, бэлчээрт хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавьжтай тэмцэхэд иргэд, малчдын оролцоог нэмэгдүүлж, байгаль орчинд халгүй, дэвшилтэт аргыг ашиглана.

1.2.11. Бог малын хээлтүүлэгчийг иргэд болон мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн мэдэлд гэрээ, түрээсээр өгч маллуулах ажлыг зохион байгуулна.

1.2.12. Мал эмнэлгийн анхан шатны нэгжүүдийг бэхжүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд хөнгөлөлттэй зээл, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр дэмжлэг үзүүлнэ.

1.2.13. Мал эмнэлгийн анхан шатны нэгжүүдийг эм бэлдмэл, багаж хэрэгсэл тоног төхөөрөмжөөр хангахад хөнгөлөлттэй зээл, төсөл, хөтөлбөрт хамруулж, эмийн эргэлтийн санг нэмэгдүүлнэ.

1.2.14. Мал амьтны гоц халдварт, халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах ажлыг үр бүтээлтэй зохион байгуулж оновчтой хэрэгжүүлснээр халдварт өвчний гаралтыг бууруулан мал, мах экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.

1.2.15. Мал эмнэлгийн лабораторийн оношлох чадавхийг нэмэгдүүлэх, оношлогоо, шинжилгээний аргыг боловсронгуй болгох, шинэ арга зүй нэвтрүүлэхэд жил бүр тодорхой хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлнэ.



1.2.16. Аймгийн хэмжээнд жишиг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулна.

1.2.17. Мал сүргийг эрүүлжүүлэх, бэлчээрийн болон хашаа хорооны эрүүл ахуйг сайжруулах, дадал эзэмшүүлэх зорилгоор малчдын дунд сургалт зохион байгуулна.

1.2.18. Эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоон гол нэрийн хүнсний ногооны 50-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах ажлыг дэмжинэ.

1.2.19. Чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр ханган, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.

1.2.20. Ургамал хамгааллын цогц арга хэмжээг төлөвшүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил шимийг сайжруулах, таримлын зохистой сэлгээ, тэг элдэншүүлгийн технологийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

1.2.21. Усны хайгуул, судалгаанд үндэслэн услалтын системийг сэргээн засварлах, усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг дэмжиж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.2.22. Өвөл, зуны хүлэмжийн загвар аж ахуйг хөгжүүлж, хот суурингийн хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангана.

1.2.23. Ховд голын сав газарт харьяалалтай сумдад газар тариалангийн зориулалттай техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг лизингийн аргаар олгохыг дэмжинэ.

1.2.24. Зоорь, агуулах барих санаачлага гаргасан иргэн аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар орон нутагт ургасан хүнсний ногоогоор хангана.

1.2.25. Өлгий хот болон Дэлүүн, Булган, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл, Толбо зэрэг томоохон сумдад арьс шир боловсруулах үйлдвэр байгуулна.

1.2.26. Аймаг дахь Улсын нөөцийн салбарын нөөцийн цэгүүдийг нэмэгдүүлэх агуулах, саравчинд засвар үйлчилгээ хийх ажилд дэмжлэг үзүүлнэ.

1.2.27. Мерси Кор болон бусад Олон Улсын байгууллагуудтай хамтран зорилтот сумдын малчид болон орон нутгийн эдийн засагт учирч болзошгүй болох зудын гарз хохирлыг багасгах, эрсдэлийг бууруулах чадавхийг бэхжүүлэх, тэдний урьдчилан сэргийлэх мэдээллийн хэрэглээ, гамшгийн эрсдэлийн менежментийн талаарх мэдлэгийг дээшлүүлнэ.

### **1.3. ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, СТАНДАРТЧИЛАЛ**

*Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарыг төрөлжүүлэн, орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжийг бүрдүүлж, төр болон хувийн хэвшлийн түншлэл, аж ахуйн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.*

1.3.1. Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана.



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

1.3.2.Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах иргэд, аж ахуйн нэгжүүдийн үүсгэл санаачлагыг дэмжиж ажиллана.

1.3.3.Аймаг, сум, суурин газруудын хэрэгцээг хангахуйц орчин үеийн дэвшилтэт технологи бүхий жижиг, дунд оврын хүнсний үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

1.3.4.Хүнсний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгоно.

1.3.5.Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.

1.3.6.Мал аж ахуйн бүтээгдэхүүнээр анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

1.3.7.Өлгий хотод сүү цагаан идээ боловсруулах жижиг дунд үйлдвэр болон фермерийн аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг холбох замаар иргэдийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангана.

1.3.8.Аймгийн төвд байгаа махны үйлдвэрүүдэд технологийн шинэчлэл хийхэд зээлийн бодлогоор дэмжиж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлохыг дэмжинэ.

1.3.9.Хэмжил зүйн ажил үйлчилгээнд ашиглах эталон төхөөрөмжийн баазыг бэхжүүлэн, хэмжүүр баталгаажуулалтын цар хүрээг өргөжүүлнэ.

1.3.10.Орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн аймгийн хөгжлийг дэмжих “Стандарттай Баян-Өлгий” хөтөлбөр, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.3.11.Дотоодын нөөц бололцоонд тулгуурлан “Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, жижиг дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлд хамрагдахад бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

1.3.12.Түүхий эд, боловсон хүчний нөөцөд тулгуурлан МАА-н загвар хоршоо, фермер, шувуу, зөгий үржүүлэх аж ахуй, жижиг, дунд үйлдвэрүүдийн санаачлагыг дэмжинэ.

1.3.13.Барьцаа хөрөнгө нь дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зээлийн батлан даалтад хамруулах ажлыг эрчимжүүлнэ.

### 1.4. ТӨСӨВ, САНХҮҮ

*Аймгийн төсөв санхүүгийн хариуцлага, хяналтыг сайжруулж, ил тод, үр ашигтай байдлыг эрхэмлэн, орон нутгийн хөгжлийг дэмжинэ.*

1.4.1.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийн сахилга батыг сайжруулж, ашиггүй зардлыг бууруулж, хэмнэлтийн горимд шилжүүлэн, төсвийн зарцуулалтын хариуцлагыг дээшлүүлнэ.



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

1.4.2. Санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ахиц, өөрчлөлт гаргаж, санхүү, бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулна.

1.4.3. Хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалтыг ард иргэдэд нээлттэй, ил тод болгож, барилга байгууламжийн чанарт тавих хяналтыг сайжруулж, гүйцэтгэлийн үр ашгийг дээшлүүлнэ.

1.4.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд ил тод хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлнэ.

1.4.5. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, хадгалалт хамгаалалтанд байнга хяналт тавих, хуучин барилга объектыг ажлын байр бий болгох зориулалтаар ашиглах боломжийг судалж шийдвэрлүүлнэ.

1.4.6. Банкны бүх төрлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, хөнгөн шуурхай болгох чиглэлээр арилжааны банкнуудтай хамтран ажиллана.

1.4.7. Татварын тогтолцоонд мэдээллийн технологийн дэвшилтэд арга хэлбэрийг нэвтрүүлж үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэн, хяналтын тогтолцоог хэрэгжүүлнэ.

1.4.8. Татварын төлөвлөгөөг бодитой төлөвлөж төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд биелүүлнэ.

1.4.9. Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоог үндэсний тооцооны системийн аргачлалаар тооцох, боловсронгуй болгох, далд эдийн засгийн хамралтыг сайжруулах, жилийн дундаж өсөлтийг улс, аймгийн дундаж түвшинд хүргэж ажиллана.

1.4.10. Хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн цахим сан бий болгож, улсын бүртгэлийн иргэний мэдээллийн сантай уялдуулж зөрүүг арилгах арга хэмжээ авах, сангийн баяжилт, бүрдүүлэлт, чанарын үзүүлэлтүүдийг хангаж сум, орон нутгийг холбосон онлайн сүлжээнд холбож, шаардлагатай мэдээллийг солилцох тогтолцоог бүрдүүлнэ.

### 1.5. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭР

**Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх зорилт болгон ашигт малтмалын олборлох үйлдвэрлэл эрхлэхдээ байгаль орчинд халгүй, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэн хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх замаар аймгийн эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлнэ.**

1.5.1. Уул уурхайн ордуудад түшиглэсэн ашигт малтмалыг олборлох, боёг, үйлдвэрийг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

1.5.2. Үйлдвэр, ажлаа олборлох, үйлдвэрлэл эрхлэхдээ байгаль орчинд халгүй, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэн хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх замаар аймгийн эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлнэ.

1.5.3. Уул уурхайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ашиглагдахгүй байгаа тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудыг эмхлэн цэгцэлнэ.



1.5.4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй гурван талт гэрээ байгуулах замаар бичил уурхай эрхлэгчдийн газрын асуудлыг шийдвэрлэж, ажлын байр бий болгоно.

1.5.5. Дулаан харын үйлдвэрлэлийн ашиглалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

### **ХОЁР. ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**Эдийн засгийн аюулгүй байдлын суурь үндэс болох барилга, эрчим хүч, мэдээлэл холбоо, зам, тээврийн салбарын тогтвортой, тасралтгүй, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, орон нутгийн иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг нэмэгдүүлнэ.**

#### **2.1. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ**

2.1.1. Өлгий хотыг үерээс хамгаалах далангийн инженерийн хийцтэй зураг төсвийг хийлгэж, барьж ашиглалтанд оруулах асуудлыг дэс дараатай шийдвэрлэх арга хэмжээ авна.

2.1.2. Өлгий хотын авто замыг эвдрэлээс хамгаалах, ус зайлуулах системтэй болгох асуудлыг судлан шийдвэрлэх, сургууль, цэцэрлэгүүдийн ойролцоо явган хүний гарц гаргах, хурд сааруулагч болон авто замын тэмдэг, тэмдэглэгээтэй болгоно.

2.1.3. Өлгий хот доторх шороон замыг хатуу хучилттай болгоно.

2.1.4. Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажилд хяналт тавина.

2.1.5. Аймгийн нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох замаар орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ.

2.1.6. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрыг барилгын материалын сорилт шинжилгээний лабораторитой болгохыг дэмжинэ.

2.1.7. Өлгий хотын гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулна.

2.1.8. Сумдыг газрын мэдээллийн “Лэнд менежер” программ хангамжид холбоно.

2.1.9. Өлгий сумын Ховд голд хүнд даацын авто тээврийн гүүр барих ажлыг эхлүүлнэ.

2.1.10. Жишиг сум хөтөлбөрт сумдыг хамруулна.

2.1.11. Зарим сумдын Засаг даргын Тамгын газрын болон соёлын төвийн барилгыг шинээр барьж эхэлнэ.

2.1.12. Улаанхус сумын Хөх хөтөл багийн 75 хүүхдийн цэцэрлэгийг барилгыг гадаадын хөрөнгө оруулалтаар барина.

2.1.13. Сумдын барилга байгууламж нь хуучирсан сургууль, дотуур байр, цэцэрлэгийн барилгуудад их засвар хийх, шинээр барих асуудлыг шийдвэрлэнэ.

2.1.14. Аймгийн төвд 120 ортой нэгдсэн эмнэлгийн барилга барина.



2.1.15.Бага, дунд орлоготой, гэр бүлийн орон сууцны хангамжийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн, ипотекийн зээлд хамруулах орон сууцны м2-ийн үнийн дээд хязгаарыг багасгах асуудал тавьж, залуу гэр бүл, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амьжиргааны түвшин доогуур эмзэг гэр бүлийг хямд үнэтэй түрээсийн орон сууцаар хангах хөтөлбөрийг аймаг, сумдад дэмжин хөгжүүлж, орон сууцыг дахин төлөвлөлтөд оруулах, боломжийг судлан хэрэгжүүлж иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулна.

2.1.16.Зарим бага сургуулиудад биеийн тамирын заалны барилга барих ажлыг дэс дараатай шийдвэрлэнэ.

2.1.17.Өлгий сумын Хотгор баг болон зарим сумдад цэцэрлэгийн барилгыг шинээр барина.

2.1.18.Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх техник технологийн шинэчлэлт хийж, цэвэрлэгээний төвшинг сайжруулах, бага оврын цэвэрлэх байгууламжийг барих арга замыг хэрэгжүүлнэ.

2.1.19.Түрээсийн байранд байгаа төрийн байгууллагуудыг зураг төсвийн дагуу шинээр барилга барих асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

2.1.20.Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар бүрэн дунд сургуулийн байрыг шинээр барих асуудлыг гадаадын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар шийдвэрлүүлнэ.

### **2.2. ЭРЧИМ ХҮЧ, ЦАХИЛГААН**

2.2.1. Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан шинэ суурьшлын бүсэд шинээр нэмэгдэх гэр хорооллын цахилгаан хангамжийг шийдвэрлэнэ.

2.2.2. “Шинэ Өлгий ” хороололд Цагааннуурын 35кВ-ын ЦДАШ-аас салаалан 35/6 кВ-ын хуваарилах байгууламж барина.

2.2.3. Сумдын цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулахад шат дараалсан арга хэмжээ авна.

2.2.4. Хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж байгаатай холбогдуулан дэд станцуудын хүчин чадлыг өргөтгөнө.

2.2.5. Ховд гол дахь Тавилтайн хавцалд усан цахилгаан станц барих ажилд гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжиж, өөрийн цахилгааны эх үүсвэртэй болоход анхаарна.

2.2.6. Хоёр дахь дулааны станцыг барих асуудлыг судлан шийдвэрлэх арга хэмжээ авна.

2.2.7.Сумын төвүүд болон цахилгааны эх үүсвэрт ойролцоо багуудыг цахилгаан эрчим хүчээр хангана.

2.2.8.Сумдыг нэгдсэн халаалттай болгох асуудлыг үе шаттайгаар судалж, шийдвэрлэнэ.

2.2.9. Гудамжны гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчээр хангах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.





### **2.3. МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА, ХОЛБОО**

2.3.1. Дэлүүн-Булган, Цагааннуур-Улаанбайшинт боомт хүртэл шилэн кабель татна.

2.3.2. Үүрэн холбооны сүлжээгүй газруудыг сүлжээтэй болгож, аймгийн төвд 4G сүлжээ оруулах асуудлыг шийдвэрлэнэ.

2.3.3. Аймгийн хэмжээнд мэдээлэл харилцаа холбооны суурь сүлжээг хөгжүүлэх тоон технологийн системд шилжүүлнэ.

### **2.4. ЗАМ, ТЭЭВЭР**

2.4.1. Бугат сумын Хар үзүүр, Сагсай сум болон Уурхайн чиглэлд авто тээврийн шалган бүртгэх товчоо барина.

2.4.2. Авто вокзалын барилгыг шинээр барина.

2.4.3. Хот хооронд болон сум хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулна.

2.4.4. Өлгий-Ховд, Цагааннуур-Ташаантын чиглэлийн хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна.

2.4.5. Зарим сумуудад шаардлагатай стратегийн зориулалттай бетон болон модон гүүр барих засварлах ажлыг шийдвэрлүүлнэ.

2.4.6. Ярант-Булган сум чиглэлийн хавцлын зам, Өлгий-Даянгийн чиглэлийн замыг сайжруулж, хатуу хучилттай зам тавих ажлыг эхлүүлнэ.

2.4.7. Сум хооронд хатуу хучилттай болон сайжруулсан авто зам барих зураг төсөв боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ.

2.4.8. Толбо сумын Бураат, Ногооннуур сумын Зээгт, Булган сумын Улаагчин, Даянгийн Ашлы-булах даваануудын дис станцуудыг өвлийн улиралд тогтмол ажиллуулах арга хэмжээ авна.

2.4.9. Нисэх буудлын хатуу хучилттай зурвасыг өргөтгөж, шөнийн нислэгийн зурвастай болгон хүнд даацын том онгоц хүлээж авах боломжийг бүрдүүлж, ачаа тээшийн конвертой болгох асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.

## **ГУРАВ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

### **3.1. ЭРҮҮЛ МЭНД**

**Үйлчлүүлэгчид, өрх гэр бүлийн эрхийг дээдэлсэн, эрэлт хэрэгцээг хангасан, тэгш хүртээмжтэй, эрүүл мэндийн чанартай тусламжийг үзүүлснээр эрүүл, урт наслах нөхцөл бүрдүүлэхэд чиглэгдэнэ.**

3.1.1. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, стандартын шаардлага хангасан орон байраар хангана.

3.1.2. Эрүүл мэндийн салбарын автопарк шинэчлэлтийг үе шаттай хийж, яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.



3.1.3.Нэгдсэн эмнэлэг, Сансар сувилал, сум, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийг багаж, тоног төхөөрөмжөөр хангана.

3.1.4.Хүний нөөцийг чадавхижуулж, хөдөө сумдыг нарийн мэргэжлийн эмчээр хангана.

3.1.5.Тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, чанар, хүртээмжийг сайжруулж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлснээр өвчлөлөөс урьдчилан сэргийлнэ.

3.1.6.Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулж, эрүүл мэндийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлнэ.

3.1.7.Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг өргөжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.

3.1.8.ХДХВ/ДОХ,Сүрьеэ, болон БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

3.1.9.Мэдээллийн технологийн ололт дэвшлийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлнэ.

3.1.10.Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын түншлэлийг өргөтгөж, тавих хяналтыг дээшлүүлж, бодлогоор дэмжиж ажиллана.

3.1.11.Хөдөөгийн багийн эмч нарыг чадавхжуулж, зарим багийн төвийг их эмчийн салбарын статусаар ажиллуулах асуудлыг холбогдох дээд байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ.

3.1.12. Аймгийн эрүүл мэндийн салбарын эмчийн тоог нэмэгдүүлэн, төсвийг стандартыг баримталж хуваарилуулах арга хэмжээ авна.

3.1.13. Цагааннуурын боомтоор эм, эмнэлгийн хэрэгсэл оруулах асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

### **3.2. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН**

**Сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх үүднээс боловсролын үйлчилгээ үзүүлэх байгууллагын чадавх, түүний орчны стандарт, аюулгүй байдлыг хангана.**

3.2.1.Боловсролын байгууллагын менежментийг сайжруулж, багш нарыг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлж, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, чадваржуулах тодорхой ажил зохион явуулна.

3.2.2.Сумын төвийн сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах боломжийг нэмэгдүүлнэ.

3.2.3.Стандарт бус цэцэрлэгийн барилгуудыг шинээр барьж өргөтгөх, шаардлага хангасан хашаа, гадна тоглоомын талбайтай болгоно.

3.2.4.Хүүхдийн цэцэрлэгүүдийн тоглоомын төрөл ангиллыг олшруулан, хатуу зөөлөн эдлэлээр хангана.

3.2.5.Хувилбарт сургалтын бүлгийг цэцэрлэгүүдэд нэмж ажиллуулна.



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

3.2.6.Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулах арга хэмжээ авна.

3.2.7.Сургалтын зэрэгцсэн бүлэгтэйгээр /Монгол-Казах-Тува/ зохион байгуулж буй сургуулиудын төсвийг зохих журмын дагуу санхүүжүүлж, үндэсний цөөнхийн хүүхдийг сурч боловсрох тэгш эрхээр хангана.

3.2.8. Бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийг төрийн албан ёсны хэлээр алдаагүй зөв бичих, ярих, илтгэх, хөдөлмөрийн зах зээлд бусадтай тэгш өрсөлдөх ур чадвартай болгох хэрэгцээнд нийцүүлэн, хос хэлний сургалт явуулдаг ЕБС-д монгол хэлний сургалтын цогц бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

3.2.9. Үндэстэн, угсаатны өв, соёл, зан заншлыг өсвөр үеийнхэнд эзэмшүүлэх адил тэгш боломжийг бий болгох зорилгоор хос хэлээр сургалт явуулдаг ЕБ-ын сургуулийн бага ангийн хөгжим, дүрслэх урлаг, технологи, иргэний боловсрол, хүн-нийгэм хичээлүүдийн хөтөлбөрт нэмэлт агуулгыг тусгаж, сурагчдыг гарын авлагаар хангана.

3.2.10.Хос хэл дээр сургалт явуулдаг ЕБ-ын сургуулийн 2 ба 4 дүгээр ангийн монгол хэлний сурах бичгийг багшийн номын хамт зохиож хэвлүүлнэ.

3.2.11.Хос хэлээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын төрийн албан ёсны хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор толь бичиг, гарын авлага, сургалтын материал зохиож хэвлүүлнэ.

3.2.12.ЕБ-ын сургуулийн 1 дүгээр ангийн бэлтгэл бүлгийн зөвлөмж номыг казах хэлэнд орчуулж, хичээнгүй бичгийн зөвлөмжийг CD –ийн хамт хэвлүүлнэ.

3.2.13.Цэцэрлэгийн багш, хүүхдүүдийг казах хэл дээр хэвлэгдсэн гарын авлагаар хангахад дэмжлэг үзүүлнэ.

3.2.14.Дотуур байранд амьдардаг хүүхдийн орчин, нөхцөлийг сайжруулна.

3.2.15.Онцгой амжилт гаргасан багш, сурагчдыг дэмжих, урамшуулах журам боловсруулж мөрдөнө.

3.2.16.ЕБС, дотуур байр, хүүхдийн цэцэрлэгийн хоолны газрын стандартыг мөрдүүлж, баталгаатай хоол хүнсээр үйлчлэх бүх нөхцөлийг бүрдүүлхийн зэрэгцээ цэвэр, бохир усны шугамд холбож, гүний худагтай болгоход дэмжлэг үзүүлнэ.

3.2.17.Зарим ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, хүүхдийн цэцэрлэгийн бие засах газар, гар угаагуурын нөхцөлийг сайжруулж, орчин үеийн халуун усны газартай болгоно.

3.2.18.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол олгох таатай нөхцөл бүрдүүлж, тэдний авьяас, хөдөлмөр, бүтээлийг дэмжинэ.

3.2.19. Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, бодлогоор дэмжиж ажиллана.

3.2.20.ЕБС-ийн сургалтын орчныг сайжруулах зорилгоор орчин үеийн сургалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлыг төсөл, хөтөлбөрт хамруулан үе шаттайгаар шийдвэрлүүлнэ.



### **3.3. НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТ**

**Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эрүүл амьдралын дадал хэвшлийг дэлгэрүүлж, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.**

3.3.1.Өсвөр үеийн тамирчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, аймгаас өндөр зэрэг цолтой тамирчдыг олноор төрүүлэх олон улс, тив дэлхий, олимпийн тэмцээнүүдээс медаль хүртэх зорилгоор аймгийн Засаг даргын дэргэд өсвөр үеийн шигшээ багийг спортын төрлөөр байгуулж, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

3.3.2.Хөгжих боломжтой спортын төрлүүдээр Олон улсын болон улс, бүсийн тэмцээнийг аймагт зохион явуулна.

3.3.3.Спорт цогцолборын тоног төхөөрөмж, спортын хэрэглэл, материаллаг баазыг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлнэ.

3.3.4.Усан бассейн барих ажлыг судалж хэрэгжүүлнэ.

3.3.5.Тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, тив дэлхий, олон улс, улсын чанартай тэмцээнд оролцогчдыг бүх талаар дэмжиж ажиллана.

3.3.6.Нийтийн биеийн тамир болон үндэсний спортыг хөгжүүлэх асуудлыг дэмжиж ажиллана.

3.3.7. Сумдад спортын бага олимп зохион байгуулах үйл ажиллагааг сэргээнэ.

### **3.4. СОЁЛ, УРЛАГ**

**Үндэстэн, ястны өвөрмөц соёлын үр шимийг өсвөр үеийнхэнд өвлүүлэх, соёлын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.**

3.4.1.Үндэстэн, ястны оюуны соёлыг судлах, сурталчлах, хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.

3.4.2.Үндэсний өвөрмөц онцлог соёлыг судалж улс, аймаг, орон нутгийн хамгаалалтад авах, ЮНЕСКО–ийн дэлхийн соёлын өвд бүртгүүлэх асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

3.4.3.Тус аймагт амьдардаг үндэстэн, ястны өвөрмөц ёс заншлыг судлах ажилд анхаарч төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.4.4.Аймгийн нутаг дэвсгэр дахь түүх, археологийн дурсгалын судалгааг гүнзгийрүүлэн хийж, Монгол Алтайн бүс нутагт жуулчдыг өргөнөөр татах, Монгол Алтайн хосгүй түүх-археологийн дурсгалыг дэлхий нийтэд сурталчлах ажлыг үргэлжлүүлнэ.

3.4.5.Зарим сумдын соёлын төвүүдийг үзэгчдийн сандал, тоног төхөөрөмжөөр хангана.

3.4.6.Музейн дэглэлтийг боловсронгуй болгож, сан хөмрөгийг баяжуулан, гадаадын музейнүүдийн хэмжээнд хүргэх, хөгжүүлэх бодлого барьж ажиллана.



3.4.7.Аймгийн нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

3.4.8.“Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгаас хяналт тавьж ажиллах, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэнэ.

3.4.9.Хүүхэд, залуучуудад зориулсан кино театр байгуулах хувийн хэвшлийн санаачлагыг дэмжинэ.

3.4.10.Уран бүтээлчдийг мэргэшүүлэн, уран бүтээлийн чанарыг сайжруулж, өргөн бүрэлдэхүүнээр өв соёл, зан заншлаа ард түмэнд сурталчлан таниулна.

3.4.11.Хөгжимт драмын театрын барилгад их засвар хийж, гэрэлтүүлгийг орчин үеийн технологид нийцүүлэн шинэчилнэ.

3.4.12.Үндэсний соёл, язгуур урлагийг хойч ирээдүйд сурталчлан таниулах, иргэдэд үйлчлэхэд зориулж ХДТ-ыг багтаамж нь 25-35 хүний суудалтай автобусаар хангана.

3.4.13.Номын фондыг баяжуулж, номын сангийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэн, шинэлэг үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.4.14. Аймгийн соёл, урлагийн өдрүүдийг уламжлал болгон Улаанбаатар хотод зохион байгуулна.

3.4.15.Аймагт уламжлал болгон 2 жилд нэг удаа бүх ард түмний урлагийн наадам зохион байгуулж явуулна.

3.4.16.МҮЭХолбооны түүхт 100 жилийн ой болон бусад бүх төрлийн ойн баяруудыг бүх нийтийн арга хэмжээ болгон тэмдэглэн өнгөрүүлнэ.

### **3.5. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХАЛАМЖ, ДААТГАЛ**

**Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг тодорхойлж, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн зэрэг үйлчилгээг багцлан хүргэх замаар зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулан амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.**

3.5.1.Зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлнэ.

3.5.2.Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт тулгуурласан дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

3.5.3.Өрхийн мэдээллийн санг шинэчлэх ажлыг зохион байгуулна.

3.5.4.Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хөгжүүлэх төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

3.5.5.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, сангийн орлогыг хугацаанд нь бүрдүүлэхэд хяналт тавьж сургалт сурталчилгааг байнга явуулна.

3.5.6.Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардлыг хугацаанд олгож, даатгуулагчдад чирэгдэлгүй, хүртээмжтэй үйлчилнэ.



### **3.6. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, СУРГАЛТ**

3.6.1. Хүн амын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлж, иргэдийн бүлэг, нөхөрлөл, хоршоодын санал санаачлагыг дэмжинэ.

3.6.2. Ажил олгогчийг ажлын байраа хадгалах, шинэ ажлын байр бий болгох, өндөр техник, технологи ашигладаг ажлын байраа нэмэгдүүлэхэд зориулж бага хүүтэй зээл олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогоор дэмжинэ.

3.6.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан орон нутгийн ажилгүй залуучуудыг сургаж, ажилд зуучлах, дадлагажуулан ажлын байраар хангах, хөрвөх чадвартай мэргэшсэн ажиллах хүчний нөөц бүрдүүлнэ.

3.6.4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

3.6.5. “Ахмадын зөвлөх үйлчилгээ”-г бий болгож, хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг нь өвлүүлэх ажлыг зохион байгуулна.

3.6.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэшүүлэх, үүсгэл санаачлага, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.6.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тогтвортой ажлын байраар хангасан хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад дэмжлэг үзүүлнэ.

3.6.8. Үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог хөгжүүлнэ.

3.6.9. Ажилгүй иргэд болон залуучуудад бизнесийн гарааны дэмжлэг үзүүлж, их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг тоног төхөөрөмжийн лизинг, жижиг зээлд хамруулах арга хэмжээ авна.

3.6.10. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нөхөрлөл, хоршоо байгуулах, ажлын байр нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдсэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын санаачлагыг дэмжин хамтран ажиллана.

3.6.11. Үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлнэ.

3.6.12. Туслах аж ахуй эрхлэхэд айл өрхүүдийн санал санаачлагыг дэмжинэ.

3.6.13. Сум, багийн төвд ахуйн үйлчилгээ бий болгоход туслах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

3.6.14. Аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг 2 жил тутамд аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоо, ажил олгогч эздийн холбоотой хамтран байгуулж хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.6.15. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр олон улсын донор байгууллагуудтай нягт холбоотой ажиллана.



3.6.16. Мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ оновчтой сонгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах үйлчилгээг хөгжүүлэн олон нийтэд хандсан мэдээлэл, сурталчилгаа хийх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх, мэргэжлийн зөвлөх үйлчилгээг орон нутагт бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

3.6.17. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад, дотоодод ажиллах хүч гаргах санаачлагыг дэмжинэ.

3.6.18. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээлэл, шилжих хөдөлгөөний нэгдсэн бүртгэл мэдээллийн үйлчилгээг хөгжүүлнэ.

3.6.19. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн харилцаанд оролцогчдын эрхийн зөрчлийг арилгахад анхаарч ажиллана.

### **3.7. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ**

**Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлөөр ханган ажиллана.**

3.7.1. Аймгийн төвд “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн ордон” барьж, орон нутгийнхаа ирээдүй болсон хүүхэд, залуучуудыг бүх талаар хөгжих, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх бололцоогоор хангана.

3.7.2. Үндэсний хэмжээний бодлого хөтөлбөрүүдтэй уялдуулан аймгийн онцлогийг тусгасан “Гэр бүл, хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлнэ.

3.7.3. Аймаг, орон нутгийн онцлогийг сурталчлах зорилгоор уран бүтээлч хүүхдүүдийн урлагийн тоглолтыг нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулна.

3.7.4. Хүүхэд, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэдний эрх нь зөрчигдөхөөс хамгаалах “Хүүхэд хамгааллын төв”-ийг байгуулна.

3.7.5. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах, хамтарсан багийн гишүүдийг идэвхжүүлэх зорилтыг сумдын дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгуулж, дэмжин ажиллана.

3.7.6. Бага насны хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлж, хүүхдийн осол, эндэгдлийн түвшинг бууруулах арга хэмжээ авч ажиллана.

3.7.7. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийг Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын харьяанд авч ажиллуулна.

3.7.8. Өсвөр үе, залуучуудын амьдрах ухааны ур чадварыг дээшлүүлэх, зан үйл, хандлагад эерэг өөрчлөлт оруулах нөлөөллийн шат дараалсан арга хэмжээг зохион явуулна.



## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх, өөрийн аясаар нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх замаар байгаль, хүний эрүүл мэндэд ээлтэй ногоон хөгжлийг хэрэгжүүлнэ.

### **4.1. БАЙГАЛЬ, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ЭЭЛТЭЙ НОГООН ХӨГЖИЛ**

4.1.1. Аймгийн ногоон хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.

4.1.2. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох стратеги боловсруулан хэрэгжүүлнэ.

4.1.3. Суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежмент төлөвлөгөө, агаарын бохирдлыг арилгах дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

4.1.4. “Тогтвортой хөгжлийн боловсрол” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, олон нийтэд эх дэлхийгээ хайрлах, уламжлалт ёс заншлаа дээдлэх мэдлэг олгож, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлнэ.

4.1.5. Цөлжилтийг сааруулж, бэлчээрийн талхлагдахыг бууруулан дасан зохицох арга хэмжээ авч ажиллана.

### **4.2. БАЙГАЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АЖИЛД БҮХ НИЙТИЙН ХАМТЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ**

4.2.1. Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улс, орон нутгийн тусгай хамгаалалтад авна.

4.2.2. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн хилийн заагийг тодорхойлж, байгальд ээлтэй аялал жуулчлал, ногоон хөгжлийн түшиц газар болгон хөгжүүлнэ.

4.2.3. Усны нөөцийг хамгаалж, хомсдлоос сэргийлэх нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

4.2.4. Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулж ус хангамжийг нэмэгдүүлнэ.

4.2.5. Суурин газрын ундны эх үүсвэрийг хамгаалах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.6. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээлтэд хяналт тавина.





## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

4.2.7.Ойн нөөцийг хамгаалах, үр өгөөжтэй ашиглах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

4.2.8.Устгах аюулд орсон амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах, тарьж ургуулах санаачлагыг хөрөнгө, санхүүгийн бодлогоор дэмжинэ.

4.2.9.Байгаль хамгаалах, байгалийн нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх ажил эрхэлж байгаа иргэн, нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, орон нутагт ажлын байр, орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох ажлыг зохион байгуулна.

4.2.10.Иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага тарьж ургуулсан ой, ургамал, өсгөж үржүүлсэн ан амьтан болон хурын усыг хуримтлуулах замаар нуур, цөөрөм, усан санг бий болгосон тохиолдолд урамшуулна.

4.2.11.Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эртнээс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.

4.2.12.Байгаль орчны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд хүрэх мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулна.

### **4.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

4.3.1.Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

4.3.2.Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

4.3.3.Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ.

4.3.4.Аялал жуулчлалын төвүүдийг хөгжүүлэх, дэд бүтцийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.

### **ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

*Төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй болгож, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, хяналт шинжилгээ, дотоод аудитын хяналтыг эрчимжүүлж, эдийн засгийн үр өгөөжтэй гадаад харилцааг өргөжүүлэн, чадварлаг, хариуцлагатай, хууль дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлнэ.*

#### **5.1. ТӨРИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ**

5.1.1.Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн хөгжлийг нэмэгдүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор “E-Office” дотоод удирдлагын



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

системийг нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, цаасгүй, хүнд сурталгүй хүргэж цахим засгийг бодитой хэрэгжүүлнэ.

5.1.2. Нутгийн захиргааны байгууллагын ажил, үйлчилгээнд олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо, MNS ISO 9001-2010 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

5.1.3. Аймаг, сумдын ЗДТГ-ын албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана.

5.1.4. Аймгийн хүний нөөцийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

5.1.5. Зарим багийн тоог нэмэгдүүлж, засаг захиргааны анхан шатны нэгж багийн Засаг дарга нарын хариуцлагыг дээшлүүлэн, багийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээг малчид, иргэдэд ойртуулах нөхцөлийг сайжруулна.

5.1.6. Төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлж, төрийн албаны мэргэшсэн, чадварлаг байх нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй эмзэг бүлгийн иргэдийн хөдөлмөрийг дэмжих хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

5.1.8. Төрийн захиргааны албан тушаалтан иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх хугацааг бууруулж, хөнгөн шуурхай болгоно.

5.1.9. Жендерийн тэгш байдлын хуулийг хэрэгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

5.1.10. Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулж, албан газар аж ахуйн нэгж байгууллага бүр ахмадын сан байгуулах, харьяалалгүй байгаа ахмад настнуудыг албан байгууллага аж ахуйн нэгжүүдэд харьяалуулах ажлыг шат дараатайгаар зохион байгуулна.

5.1.11. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын мэдээ, мэдээллийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж, дэвшилтэт техник технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүлнэ.

5.1.12.  $\text{Àéìàðéí òýìæýýíä öýìàèð-øèíæðèäýý, ¿íýèäýýíèé àæèüã àð°íðèé àðãà ç¿éäýýð òàíããæ, ÖØ}^{-} - íèé àæèüí í òàð ò¿äýý, ¿ð °ã°æèã íýìýã¿¿èíý.$

5.1.13.  $\text{Öýìàèð-øèíæðèäýý, ¿íýèäýýíä ñòì, àãáíðèäãòòãüã á¿äýí òàìðòòèæ,}$  дотоод аудитын үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

### 5.2. ГАДААД ХАРИЛЦАА

5.2.1. ОХУ, БНХАУ, Казахстан улсын хөрш зэргэлдээ аймгуудтай найрамдалт харилцааг гүнзгийрүүлэн, боловсрол, эрүүл мэнд, худалдаа, эдийн засаг, харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, гаалийн боомтыг ашиглан тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2.2. Дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэндийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

5.2.3. Холбогдох дээд байгууллагуудтай хамтран хил орчмын худалдааг хөгжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын зорчих нөхцөлийг сайжруулах, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграц, дэд бүтцийн сүлжээнд хамрагдах үйл явцыг эрчимжүүлэн, гадаад худалдааны тааламжтай нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2.4.Экспортлох боломжтой бараа бүтээгдэхүүний судалгаа гаргаж, гадаад зах зээлд борлуулах нөхцөлийг сайжруулна.

5.2.5.Тус аймгаас гадаадад сурч, амьдран ажиллаж буй иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрт хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

5.2.6.Аймгийн түүх соёлын өв уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилт, хөгжил дэвшил харилцаа хамтын ажиллагааг дэлхий нийтэд, сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх, Казах, Урианхай, Дөрвөд, Тува иргэдийн өвөрмөц соёлыг сурталчилсан үзэсгэлэн, яармаг, кино, соёл урлагийн тоглолт, өдөрлөг, уулзалт ярилцлага зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулахад анхаарал тавина.

5.2.7.ОХУ, Казахстан, Турк улсын болон бусад орнуудын их дээд сургуульд оюутан элсүүлэх, сургах үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.

5.2.8.Багш, эмч бусад мэргэжлийн хүмүүсийг хөрш зэргэлдээ болон дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад мэргэжил дээшлүүлэх боломжийг судалж шийдвэрлүүлнэ.

5.2.9.“Алтай бидний нийтийн гэр” олон улсын төслийн хүрээнд явагдах мини хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож нутгийн хөгжлийн үзэл баримтлалыг хамтран хэрэгжүүлэх ажиллагааг дэмжинэ.

5.2.10.“Өвсний үндэс”, “Норвегийн хөгжлийн сан”, “Дэлхийн зөн” зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, орон нутагт төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

### **5.3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

*Хууль эрх зүйн сургалт сурталчилгааг шинэ шатанд гаргаж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрхийг дээдлэх зарчмыг баримтална.*

5.3.1.Хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийн хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, албан бус сургалтыг тогтмол зохион байгуулах, түүнд шаардагдах санхүүжилтийг нь шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.

5.3.2.Авилга, хүнд сурталтай тэмцэн, шударга бус зүйлийг үл тэвчих нийгмийн орчинг бий болгох зорилгоор “Авилгаас ангид аймаг” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

5.3.3.Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулна.

5.3.4.Хил хамгаалах, хууль хяналтын байгууллагын ажилчдыг ажиллах нөхцөлөөр хангаж, хууль, хяналтын байгууллагуудын техник тоног төхөөрөмжийг шинэчлэн хуульд заасан үүргээ стандартын дагуу хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

5.3.5.Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах сургалт, семинар, сургууль, тэмцээнийг зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахыг дэмжиж ажиллана.

5.3.6.Гүний усны сургалт, дадлагын цогцолборыг “Толбо” нуурын эрэгт байгуулна.

5.3.7.Аймгийн харьяаллын зөрчилтэй иргэдийн зөрчлийг арилгаж харьяалалд оруулна.

5.3.8.Цагдаагийн байгууллагын дотоод холбоо, мэдээллийн нэгдсэн систем болон бэлэн бус торгуулийн системийг бүрэн нэвтрүүлж, түргэн шуурхай, иргэдэд чирэгдэлгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.3.9.Цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг иргэд, олон нийтэд түргэн, шуурхай хүргэх зорилгоор Өлгий сумын 6, 9, 10 дугаар багийн нутаг дэвсгэрт “Цагдаагийн бичил төв”, Цэнгэл суманд Цагдаагийн тасаг, Дэлүүн суманд Цагдаагийн хэсэг байгуулна.

5.3.10. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинэ шатанд гаргах зорилгоор олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг бүх шатанд дэмжиж, гэмт хэрэгтэй тэмцэхэд иргэдийн оролцоог ханган ажиллана.

5.3.11.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилгоор замын уулзвар, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагыг камержуулах, дохиоллын системд бүрэн холбоно.

5.3.12.Архи, тамхины худалдааны үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг сайжруулах иргэдийн хэрэглээний соёлыг сайжруулна.

5.3.13. Өрсөлдөөний тухай хууль болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хэрэглэгчдийн эрх ашгийг зөрчиж байгаа аливаа хэлбэрийг тодорхойлон зөрчлийг арилгах арга хэмжээ авна.

5.3.14.Хэв журам сахиулах, хууль сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн бус байгууллагуудыг дэмжиж, татан оролцуулна.

5.3.15.Хил орчмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай зарим хилийн шугамд тор татах асуудлыг шийдвэрлэнэ.

### **5.4. БАТЛАН ХАМГААЛАХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

5.4.1.Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулахад шаардагдах сургалтын материаллаг баазыг бүрдүүлнэ.

5.4.2.Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах арга хэмжээнд шаардагдах сургалтын материал, техник хэрэгслээр хангана.

5.4.3.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор дайчилгааны бэлтгэл нөөцийн давтан сургалтын чанарыг сайжруулж, холбогдох техник хэрэгслээр хангах ажлыг дэмжиж ажиллана.



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

---

5.4.4.Цэргийн байгууллагуудын нэгдмэл үйл ажиллагааг хангаж, цэргийн захиргааны удирдлагыг төлөвшүүлж, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй цэргийн байгууллагуудын харилцан ажиллагааг сайжруулна.

5.4.5.Цэргийн албыг иргэний төлөвшил, эх оронч үзэл, хүмүүжлийн үндэс байх бодлогыг хэрэгжүүлж, иргэн цэргийн харилцааг бэхжүүлж, иргэдэд эх орноо хамгаалахад оролцох, цэргийн боловсрол, бэлтгэл эзэмшүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

5.4.6.Орон нутгийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Нийт 5 бүлэг, 23 дэд бүлэг, 265 зорилт

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_



### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2017-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

1. “Үнэ тогтворжуулах” дэд хөтөлбөр
2. “Аймгийн бренд бүтээгдэхүүн” хөтөлбөр
3. “Монгол малчин” дэд хөтөлбөр
4. “Малжуулах” дэд хөтөлбөр
5. “Стандарттай Баян-Өлгий” хөтөлбөр
6. “Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх” аймгийн дэд хөтөлбөр
7. “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөр
8. “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах” дэд хөтөлбөр
9. “Гэр бүл, хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх” дэд хөтөлбөр
10. Аймгийн ногоон хөгжлийн хөтөлбөр
11. Өлгий хотын агаарын бохирдлыг арилгах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
12. “Тогтвортой хөгжлийн боловсрол” дэд хөтөлбөр
13. “Авилгаас ангид аймаг” дэд хөтөлбөр

### ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”,
2. “Аймгийн хүний нөөцийн цогц бодлого”
3. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох стратеги